

## **ШУА-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ АКАДЕМИЧ Г.ЧУЛУУНБААТАРЫН ХЭЛСЭН ҮГ**

Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Цар тахлын онцгой дэглэм үйлчилсэн бүтэн жилийн хугацаанд дэлхий нийтээрээ ажил амьдралын хэв маяг, үйл ажиллагаагаа цахим хэлбэрт шилжүүлэн төлөвлөсөн ажлуудаа үр дүнтэй зохион байгуулж байгаа билээ.

Монгол Улсын ШУА, түүний харьяа хүрээлэнгүүд энэ хугацаанд судалгаа шинжилгээний ажлаа хэвийн явуулж, үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсаар байгаа юм. Өнөөдөр Монгол Улсын Гадаад харилцааны яамны дэмжлэгтэйгээр Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрхлэн зохион байгуулж байгаа “Олон улс судлал 2020: Монголын Хятад судлал” эрдэм шинжилгээний хурал бол миний ойлгож байгаагаар улиран одож буй 2020 оны отгон хурлуудын нэг болох юм.

Монгол Улсын гадаад бодлого, олон улс судлалын чиглэлээр академик болон бодлогын практик судалгааг дагнан эрхэлдэг эрдэм шинжилгээний тэргүүлэх байгууллагын хувьд ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн стратеги төлөвлөгөө, судалгааны тэргүүлэх чиглэлээ шинэчлэн боловсруулж, тэр дагуу тодорхой санаачилга гарган идэвхтэй ажиллаж байгаа билээ. Тэрхүү стратеги төлөвлөгөөнд жил бүр гадаад харилцаа, бодлогын тулгамдсан чухал асуудлаар “Олон улс судлал” хэмээн нэрлэсэн цуврал брэнд-хурал зохион байгуулж байхаар тусгасны дагуу Хятад судлалын асуудлаар ийнхүү анхны хурлаа эхэлж байгаа юм байна.

БНХАУ-ын нийгэм, эдийн засгийн эрчимтэй хөгжил, манай улсын хувьд өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй Хятад улсын хүчин зүйл, нөлөөг харгалзан үзвэл “Хятад судлал”-ын асуудал яах аргагүй Монгол төрийн гадаад бодлого, манай улсын гадаад харилцааны судалгааны амин чухал тэргүүлэх чиглэл мөн юм. “Ковид-19” цар тахлын улмаас дэлхий даяараа хямрал, хүндрэл бэрхшээлтэй нүүр тулсан ийм цаг үед болон Ковидын дараах хүн төрөлхтний хөгжлийн шинэ дүр төрх бүрэлдэхэд Хятадын хүчирхэг эдийн засаг, эрчимтэй хөгжил шийдвэрлэх нөлөө үзүүлэх нь эргэлзээгүй ээ. Манай хүн зоны амьдрал ахуй, эдийн засгийн хөгжилд асар их нөлөө үзүүлдэг их хөрш улсын хувьд Ковидын үеийн болон түүний дараах Монгол Улсын хөгжил Хятадын хүчин зүйлээс шууд хамаарах нь бас тодорхой билээ.

Манай эрдэмтэн судлаачид Хятадын хүчин зүйл, Хятад судлалыг онцгой анхаарч, багагүй туршлага хуримтлуулсан хэдий ч нөхцөл байдал түргэн өөрчлөгдөж байгаа энэ цаг үед Хятад судлалыг улам эрчимжүүлэх, судлаачдын залуу халаа үеийг бэлтгэх, Хятад судлалын асуудлаарх байгууллага хоорондын харилцааг тодорхой болгох, уялдааг улам сайжруулах зэрэг тулгамдсан асуудлууд урган гарсаар байгаа нь Олон улсын харилцааны хүрээлэнгээс энэ удаагийнхаа хурлын хэлэлцэх сэдвийг Хятад судлалаар сонгох үндэслэл болжээ гэж ойлгож байна.

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн бол манай улсын Хятад судлалын академик чадавх бүхий эрдэм шинжилгээний төв байгууллага мөн. Үе үеийн Хятад судлалын нэрт эрдэмтэн мэргэд энэ хүрээлэнд ажиллаж, тухайн цагийнхаа Монголын Хятад судлалын өнгө төрхийг тодорхойлсон бүтээл номоо туурвиж, Монголын Хятад судлалын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсоор ирсэн билээ. Эрдэм судлалын энэ гайхамшигтай уламжлалыг үе үеийхэн өвлөн залгамжилж, өдгөө ч өсвөр залуу үеийнхэн маань нэр төртэй үргэлжлүүлж байгаагийн нэгэн илэрхийлэл бол өнөөдрийн энэхүү эрдмийн хэлэлцүүлэг мөн гэж би үзэж байна.

Орчин үеийн Монголын Хятад судлалын суурийг тавилцсан ахмад буурлуудын маань нэг, Олон улсын харилцааны хүрээлэнг олон жил удирдаж ажилласан манай нэрт түүхч, академич Ч.Далайн 90 насны ой энэ онд тохиож байгаа гэдгийг Та бүхэн мэдэж байгаа. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд олон чухал ажил хийгдэж байгаагийн сүүлчийн хоёр буюу ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, академичийн 9 боть бүтээлийн нээлтийг өнөөдөр бид хийх гэж байна.

Энэ удаагийн эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөрт орсон мэргэжлийн эрдэмтдийн сонирхолтой илтгэлүүд ч, академич багшийн маань 9 боть бүтээл ч манай Хятад судлалын эрдмийн сан хөмрөгийг олон талаар баяжуулах нь эргэлзээгүй юм.

Өнөөдрийн хурлын хөтөлбөрийг харахад манай улсын хятад судлалын голлох эрдэмтэд, ялангуяа, олон сайхан залуу судлаачид маш сонирхолтой сэдвүүдээр илтгэл тавьж хэлэлцүүлэхээр төлөвлөсөн байна. Эрдмийн энэ хэлэлцүүлэг орчин үеийн Хятад судлал; Хятад, Монголын харилцаа, манай их хөршийн талаарх гадаад бодлогын тулгамдсан асуудлыг судалж шийдвэрлэх шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэл дүүрэн байна.

Хурлыг санаачлан зохион байгуулсан хүрээлэнгийн хамт олон, энэ арга хэмжээг бүх талаар дэмжсэн Гадаад харилцааны яаманд чин сэтгэлийн талархал илэрхийлж, шинэ оноо сайхан угтахын ерөөл өргөж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.